

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэрэндагва	Дугаар	L230
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Хишиг-Өндөр сумын төв
Төрсөн газар	Хишиг-Өндөр сум	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Авзагын хүрээ	Сүм хийдийн дугаар	БУХӨ 056
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Авзагын хүрээ буюу Баруун Соо гүний хүрээ

Д.Мөнхбат: Тэгэхээр Цэрэндагва гуай бол таван настай Авзагын хүрээнд сууж эхэлж 22 настай тэр үеийн хэлээр бол шар хувцас байсан юм байна. 17 жил хүрээнд суусан ийм буурал байна.

Тэгэхээр сайхан зүсч байна уу та?

Цэрэндагва: Сайн сайн сайхан зүсч байна уу.

Д.Мөнхбат: Тэгэхээр Түшээт хан аймгийн олон хурал номын газрууд байдаг юм байна .Тэнд болбол одоо энэ Түшээт хан аймгийн Авзага уулын хошуу гэж Авзага хайрханыхаа нэрээр нэрлэгдсэн энэ томоохон хүрээ хийдэд бол таныг бага насаа өнгөрөөж 17, 18 жил суусан гэж сонссон.Тэгэхээр та одоо энэ хүрээнд анх яаж оров, ямар багш дээр очиж одоо хадаг өргөж байв. Тэгээд тэр үеийн хүрээ хийдэд хичнээн ламтай байсан юм, цам майдар зэрэг шашны ямар ямар үйл явуулдаг байв, гол одоо уншлага нь юу байсан юм, гол шүтээн сахиус нь юу байсан юм гээд энэ хүрээ хийдийнхээ талаас одоо бидэнд хуучилж өгөөч?

Цэрэндагва:За хүрээ хийдийн гол уншлага, гол сахиус нь Гомбо сахиустай байсан., 100-аад хоньтой байсан.За тэгээд энэ хүрээ бол 5 дацантай байсан, Чойр дацан, Жүд дацан , Гүнрэг дацан, Дүйнхор дацан , Мамба дацан энэ тэр гээд 5 дацан.

Д.Мөнхбат: Тэр үед хичнээн лам нартай байсан юм бол?

Цэрэндагва: 100-аад лам нартай байсан

Д.Мөнхбат: Тэгэхээр хүрээ маань анх байгуулагдсаныг та сайн мэдэхгүй байна гэж хэлж байсан тиймээ.Ер нь бол энэ суурин дээрээ лав 100 гаруй жил болсон гэж үзэж байсан тиймээ. Тэр бол үндсэндээ таныг шавилж суусан үед 100 гаруй жил болсон гэдэг чинь.Тэгэхээр чинь 1934 он...мөхөхийнхөө өмнө л 100 гаруй жил мандаж байсан гэсэн үг.Тэгэхээр энэ хүрээний гол уншлага шүтээний талаар та хэллээ тиймээ.Тэгэхээр аймаг гэж бас байсан байх нь тиймээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэрэндагва: Тийм 4 аймагтай байсан юм.Дэлчин гэдэг нэг аймаг, Сандан гэдэг нэг аймаг, Шадавлин гэдэг нэг аймаг, Санлин гэдэг нэг аймаг ийм 4 аймагтай

Д.Мөнхбат: Нийтдээ одоо сүм дуган дацангаа нийлүүлээд тоолбол хэд орчим барилга байсан юм бол оо?

Цэрэндагва: Аа энийг тооцож болно. Нөгөө 5 дацан, 5 дуган байж байгаа. Тэгээд гол цогчин дуган „Ингээд одоо 11 дугантай

Д.Мөнхбат: Тэгээд тойроод одоо лам нарын амьдардаг хашаа байшин байгаа?

Цэрэндагва: Өө тийм байлгүй яахав

Д.Мөнхбат:Тэгэхээр одоо монголын хүрээ хийдүүд бас одоо шашныхаа хурал номыг хийх дэг , ая дан гэж байна даа тиймээ.Тэрүүгээрээ бас өөр онцлогтой, дүр төрхтэй байсан байх нь тиймээ.Тэгэхээр Авзагын уулын хүрээ маань хаанахын ямар дэг жаягтай байсан юм бол оо?

Цэрэндагва: Өө энэ бол одоо урд урдаасаа уламжилж ирсэн.Манай хүрээ хийд бол энэ ойр хавийн хүрээ хийдтэй таардаггүй байсан.Уншиж таарахгүй, янз ерөөсөө таарахгүй байсан байх.Тэр бол дээр үеэсээ уламжилж ирсэн ийм ая дантай байсан.Энэ бол одоо тэр Галдан бошигтын үхэр тэрэгнээс тасарч ирсэн хүрээ

Д.Мөнхбат: Яг гарал үүсэл нь бол?

Цэрэндагва: Тийм тийм

Д.Мөнхбат:Тэгэхээр энэ Халхын Буддын шашны хүрээ хийдүүд дотроо тухайн хүрээ хийдээс гаралтай эрдэм номд мэргэшсэн хутагт , хувилгаан, томоохон мяндагтангууд их л олон байжээ. Ер нь энд тэнд...Тэгэхээр Авзагын хүрээнээс төрсөн эрдэм чадалтай лам нарыг дурсахад?

Цэрэндагва: Өө байна.Хүрээ хамба гэж том лам гэж байсан. Тэр бол Богдын хүрээг байгуулж байсан ,эрдэм мэдлэгээрээ. Манай энэ Шандад байсан тийм лам байгаа юм. Манай хошууны лам Новуусэрээтэн гэж нэг залагдсан лам байсан .Тэр бол уг нь урд байсан хүн.Манай Новуу хутагт залсан юм .Тэгээд сүүлд нь одоо бүр Хүрээ хутагт гээд байж байгаад.таалал болсон .

Д.Мөнхбат: Одоо тэгээд тэр лам бараг Авзагын хүрээний хамгийн сүүлийн хамба гэж хэлж болох уу?

Цэрэндагва: Хамгийн сүүлийн хамба нь биш л дээ.Ширээт лам гэж тусгай лам байсан юм.Хамба нь гэх юм бол ондоо улс л байгаа

Цэрэндагва: Хүрээ хийдүүд одоо хажуудаа жас сантай байсан.Тэгэхээр Авзага уулын хүрээ хэр зэрэг жас сантай байсан юм бол оо?

Цэрэндагва: Манай Авзага ууланд баруун майдар гэж том жас байсан.Тэр жасын мал бол 4 түм хүрсэн юм түм хүрэхлээр нь ямар тэмдэг тавих вэ гэхлээр толгойныхоо 4 хутагт нь 4 ганц хавирга углачихсан байсан

Д.Мөнхбат:4 түм гэхээр чинь одоо 40000 гэсэн үг ш дээ.За одоо ийм жас сан хөмрөгтэй байжээ.Тэгэхээр энэ одоо хойд зүгт ойрхон байгаа Түшээт хан аймгийн томоохон хүрээ хийдийн нэг Вангийн хүрээ, за зүүн тийшээ бас ойрхон байгаа Эрдэнэ хамбын хийд ч юмуу за мөн Зүүн Соо гүний хүрээ ч гэдэг юмуу энэ хурал номын газруудтай хэр холбоотой байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэрэндагва: Аа тэр хурал номын талаар бол холбоотой байсан.Тэгэхэдээ бол бие биендээ ирж очиж хурж байсан, цам мамаар бол ирж очиж цам дэглэж байсан. Ийм харьцаа бол байсан л даа

Д.Мөнхбат: Ер нь тухайн бүс нутаг дахь томоохон хүрээ хийдүүд, өөрийнхөө салбар хүрээ хийд, цагийн хурлуудыг бол төөрүүлж гаргасан байдаг.Тийм цагийн хурлууд одоогийн Гурван булаг гэдэг юмуу,Хишиг- Өндөр сумын нутгуудад Авзагын хүрээнээс хэр гаргаж байсан юм бол?

Цэрэндагва: Аа Авзагын хүрээ бол цагийн хурал ихтэй.За шинэ гарсны дараа болвол тэр гол цогчин дуганд Хайлангийн хурал гэж ..Тэр 25-наас авахуулаад л 25 хүртэл.Энүүнд их юм хурдаг гэж ярьж байгаа.За тэрний дараа бол аймгуудын хурал бас болно.4 аймагт 4-үүлээ хурал болно.За тэр дацангууд бол бас тусдаа тусдаа хуралтай. Жүд дацан бол тэр ном хурсан гавжууд маарамбуудтай ийм дацан .За Жүд дацан байна.Жүд дацан бол бас нарийн дэг жаягтай. За тэгээд тэр бол тусгай хуралтай ,сар сараар хуралддаг.Ер нь сар бүр хуралтай .За тэр Гүнрэг дацан бол жилийн хуралтай.Тэгээд тэр жилийн чинь хурлууд бас хааяа хааяа хурна. Дүйнхэр дацан бол одоо 6 дацан байна..Тэр тусдаа тусдаа бас цагийн хуралтай.Тэгээд тийм цаг цагийн ийм хуралтай

Д.Мөнхбат: Тэгэхээр одоо бас ийм цагийн хурлууд гэж хөдөө хүрээ хийдээс хол байгаа газруудад нэг дуган юмуу нэг сүм барьчихаад тэгээд одоо хүрээнээс лам нар очиж хаврын билгийн тооллын эхээр байдаг юмуу, эсвэл намрын хайлангийн үеэр хурал хурчихаад тэгээд хүрээндээ эргэж ирдэг ч байдаг юмуу, тэгээд бас тэр уулын мұхарт байгаа сүм дуганд нь тахилч лам үлдээд хүж зулыг нь асаагаад байж байдаг ийм цагийн хурлууд их байжээ.Тэгэхээр одоо Авзагын хүрээний салбаруудад гарсан тийм цагийн хурал Хишиг-Өндөр сумын яг хаана хаана байсан юм бол оо?Гурван булаг суманд ч гэдэг юмуу?

Цэрэндагва: Тэр Долоон Хүдгийн хурал, Хашаатын хурал,Толийн хуралд, Баганы хуралд,Баавайн хуралд за тэгээд голын цаад талд Цамбын хуралд...аа энэ Хайдан вангийн Уртын хуралд...

Д.Мөнхбат: Энэ Бэйсийн хуралд байсан уу үгүй юу?

Цэрэндагва:Аа тийм байх

Д.Мөнхбат:За тэгэхээр ямар ч байсан 8, 9 газар байсан юм байна тиймээ.Энэ цагийн хурлыг одоо Авзагын хүрээнээс лам нар ирж уншиж байсан юм болов уу, Настай лам нар нутагтаа очоод тэр цагийн хурал, сүм дуган байгуулж байсан юм болов уу?

Д.Мөнхбат:Манай хүрээний лам нар ирж уншдаг байсан юм. Долоон хүдгийн тэнд ойролцоо нутагтай улсууд бол тэндээ очиж уншина.Хашаатад нутагтай бол тэндээ хурдаг байсан байхгүй юу, тэгээд цагаан сараар лам нар хурдаг...

Д.Мөнхбат: Нэг ээлжиндээ хэдэн хурал хурдаг байсан юм бол?

Цэрэндагва:Аа нэг хоёр , гурван хурал хурна.

Д.Мөнхбат: Тэгээд л нөгөө хэдэн лам очоод л?

Цэрэндагва: Тийм, сахиулууд очоод...Тэгээд л нөгөө хамбын хурал хураад л

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Тэгэхээр та түрүүн ярилцлагадаа хальт дурдаад өнгөрч байсан.Жишээлбэл одоо Чойрын дацан гавж ,маарамба, аграмбын дамжаа байдаг байсан. Тэгэхээр Авзагын хүрээ бол одоо дамжаа хичээллүүлж зэрэг дэв олгодог байсан уу?

Цэрэндагва:Гавжийн дамжаа байсан, аграмбын дамжаа байсан , маарамбын дамжаа байсан.Маарамбын дамжаа гэдэг нь эмчийх байна. Тийм энэ 3 дамжаатай байсан

Д.Мөнхбат: Тэгэхээр зүгээр нэг 18, 19-р зууны үед д юм даа Манжийн дарлалын үед Монголд байгуулагдсан сүм хүрээ хийдүүдийг үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл тамга тэмдгийг Манжийн хаан олгож байсан гэдэг тийм нэг түүх байдаг юм.Та тэр тухай сонссон уу, ер нь манай томоохон хүрээ хийд манжийн хааны тийм нэг зөвшөөрөл зарим газар байсан байгаа юм даа. Ялангуяа Архангай аймгийн хойд тал, Хөвсгөл аймгийн урд талаар?

Цэрэндагва: Манай энд бол байсан.Манай хийд бол Дөчтийн хүрээ гэж гаргасан. Тийм Дөчтийн хүрээ...дөчин лам хурдаг байсан.

Д.Мөнхбат: Аа тийм 40-өөс илүү лам хурдаггүй байсан?

Цэрэндагва: Манжийн хааны зарлиггүй бол...Тэгээд сүүлдээ 1000 хүрсэн л дээ

Д.Мөнхбат: Бас зарим хөгшчүүлтэй ярьж байхад нэг сонирхолтой юм байна лээ л дээ.Тэр үйл ажиллагаагаа явуулах зөвшөөрлийн бичгэн дээр байж болох лам нарых нь дээд тоог хэлээд байсан байгаа юм.Одоо заавал хэлж байгаа юм, танайх одоо 100 ламтай л байна,100-гаас илүү байж болохгүй, танайх бол нэг 85-тай байна, Тэрнээс хэтрэхгүй гэдэг ч юмүү.Тэр бол зүгээр бас учир начирыг нь олохоосоо илүү хүрээ хийдэд олон лам нарыг бөөгнүүлэх тиймээ, үзэл санааны тийм том төв болно ш дээ тиймээ ,тэр хийд.Сүсэгтэн олны очих байдал бас ихэснэ тиймээ.Бараг энэ монголчуудаас болгоомжилсон бодлого шахуугаар баримталж байсан юм шиг байгаа юм тиймээ.Үүн дээр одоо та энэ хийдэд сууж байсан хүний хувьд ямар саналтай байна?

Цэрэндагва:Үгүй одоо 40 ламтай л байсан юм. Тэгж л манжийн хаан одоо бүр зарлигдаад.40-өөс илүү байвал энэ болохгүй л байсан байх

Д.Мөнхбат: Тэгэхдээ бол ямар ч байсан 1000 хүрч байсан?

Цэрэндагва: Тийм , сүүлдээ л одоо 1000 хүрч байсан.

Д.Мөнхбат:За тэгэхээр 1937, 1938 оны тэр хэлмэгдүүлэлтийн цөвүүн цаг бол Авзагын хүрээг тойрч гараагүй, дайраад өнгөрсөн.Та тэр үед 22 настай хар болж байж дээ .Тэгэхээр яг энэ Авзагын хүрээ мөхөхийнхөө өмнө энэ цөвүүн цагтай учирахаасаа өмнө, сүүлчийн хамба нь хэн гэдэг хүн байсан юм бол, яг хичнээн лам хүрээ хийдийнхээ гал голомтыг болгоод л байж байсан юм бол?

Цэрэндагва: Намсрай хамба гэж байсан. Хамгийн сүүлийн хамба. Лам нар нэг 400-аад байсан байх.Цаанаа хуралгүй лам нар байсан л даа , жинхэнэ хуралд ордог лам нар нь 400-аад байсан байх

Д.Мөнхбат: 1000-аад лам байсан байх тиймээ, тэгэхээр 1937, 1938 оны хэлмэгдүүлэлтийн он жилүүд тэр цэвүүн цагт лам нарыг нь баривчлаад, дунд лам нарыг нь хүчээр цэрэгт явуулж байхад хүрээ хийд хоосроод үлдэж байсан уу, зарим хүрээ хийд бол хоосроод тэрнээс 5, 10 жил эзгүй байгаад 1940, 1950-аад оныг ч үзсэн байдаг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

юм.Одоо ном судрыг нь тараагаад шатаагаад хаячихсан , шувууны сангас болчихсон ингээд байж байдаг юм. Зарим хүрээ хийд дээр бол лам нарыг нь баривчилж авангуутаа л хүрээ хийдийг нь тэр дор нь галдан шатаагаад устгаж байсан байх юм.Тэгэхээр энэ Авзагын хүрээ бол ямар замыг туулсан юм бол оо?

Цэрэндагва: Лам нар баригдаад нэг 3 жил болж байлаа. Жил болоход тэр хэвээрээ л байсан.Одоо манай энэ хийд чинь бурхан тахил нь хэвээрээ байж л байсан

Д.Мөнхбат: Сүм дуган нь яг хэвээрээ юу?

Цэрэндагва: Хэвээрээ байсан.Ингээд 3 жил болсон. 3 жил болоод аймгаас тусгай улсууд ирээд бурхан номыг нь шатаасан .Цөмийг нь шатаагаад устгаад түлээд ингээд хоосон хийд үлдсэн.Тэгээд тэр хоосон хийдийг чинь сүүлд нь буулгачихсан.Тэгээд одоо хоршоонд тэр дуганыг аваарай гээд сургууль болсон.Тэгэхэд чинь нэг үйлдвэр гар урлал гэсэн юм байсан.Лам нарын артель. Бид нар тэр артельд чинь орчихоод ажил хийж байсан

Д.Мөнхбат: Хар болчихоод?

Цэрэндагва:Үгүй ээ, хар болоогүй ,лам хэвээрээ албан татвараа өгөөд. Тэгээд 2, 3 жил байж байгаад тэндээ гэртэй. Тэгээд лам нарын артельд байж байхад тэгээд л тэр хийдийг хуу нураагаад авчихсан

Д.Мөнхбат:Тэгээд л нурааж авчраад л ?

Цэрэндагва:Тэгээд л яахав байшин майшин барих нь бариад л байсан.Тэгээд л манай артельд цогчин дуганыг нь оруулж ирээд л. Цогчин дуганыг нь хоршоо луу авааччихсан Тавин хэдэн онд .Тэгээд буулгах хүн байдаггүй ганцаараа буулгах гэсэн чинь бараг хүчрэхгүй шахуу тэгээд, артелыхныг буулга гээд. хоршоо...хувааж авна. Талыг нь манайх авна гээд/ инээв/ Тэрнийг буулгаад одоо тэгээд хоосон дуган .Тэгээд буулгаж аваад манайхан чинь ..

Д.Мөнхбат: Лам нар буулгаж дээ

Цэрэндагва: Артелуудтайгаа тэгээд л тэгж байлаа. Маани.уншив../инээв/

Д.Мөнхбат: Тэрүлс төрийн хэлмэгдүүлэлт гэж нэрлээд байгаа тэр цөвүүн цагийн шуурганд Авзагын хүрээнээс хичнээн лам нар явсан юм бол, хэд нь сураггүй болсон юм бол хэд нь одоо хорих ял сонсоод тэгээд нутагтаа буцаж ирсэн юм бол ер нь тэгээд одоо Авзагын хүрээнд сууж байсан таниас өөр ийм лам байна уу?

Цэрэндагва: Надаас өөр хүн одоо ганц хоёрхон байна.Могодод нэг 95-тай хүн байдаг юм.Одоо энэ аймагт Ерөөлтсан гэж 90 дөхөж байгаа нэг хүн байна..Ийм 2 хүн байна

Д.Мөнхбат: Баригдаад явсан лам нар хэр олон байдаг юм бол, буцаж ирээгүй лам нар нь хэр олон байдаг юм бол?

Цэрэндагва:Аа буцаж ирээгүй лам гэвэл ихэнх нь ирээгүй. Баригдаад явсан лам нар чинь одоо 2 гуч машин 3 дахиж ирсэн.Тэгэхээр чинь одоо хэд болдог юм бол..

Д.Мөнхбат: 6 машин л болж дээ. Тэр үед нэг машинд 20 хүнээр бодохоор чинь 100 гаруй хүн байж дээ.30-аар бол 180-аад хүн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэрэндагва:200-аад хүн баригдсан байх аа.Тэгээд тэр бол ор сураггүй.Сүүлд нь ахиад бас явсан .Тэгээд тэр бол ажил хийж байгаад гараад ирсэн. Тийм улсууд байгаа.Академид ажил хийж байсан хүнийг ч бариад авсан.Бид нар бол яахав дээ ойр хавьдаа тэгээд...хүүхэд шуухад юм болохоор тоохгүй.

Д.Мөнхбат: За ингээд Авзага уулын хүрээний талаар мэдээлэл өгсөн өөрийн сууж байсан хийдийнхээ тухай ярилцаж суусан танд баярлалаа. Таны өгсөн мэдээлэл манай судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.Та урт насалж удаан жаргаарай.

Цэрэндагва: Ерөөл бат оршиг ээ